

## НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, СУДЛАГДСАН БАЙДАЛ

Өнөөдөр хэрэглэгч төвтэй, тэдний хэрэгцээнд нийцсэн чанартай, аюулгүй, ёс зүйтэй тусламж, үйлчилгээг чухалчилж байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамж нь тухайн байгууллагын үйлчилгээнээс гадна өвчний эдгэрэл, онцлогтой уялдсан хийсвэр хүчин зүйлс болон чанарын үзүүлэлтийн нөлөө ихтэй, хэлбэлзэл ихтэй байдгаараа бусад салбараас онцлог байдаг.

Гэсэн хэдий ч хэрэглэгчийн сэтгэл ханамжийг, Тухайлбал тусламж үйлчилгээний юу нь таалагдаж, юу нь эс таалагдаж байгааг болон тэдний эрэлт хэрэгцээг судлах замаар эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, өөрчлөлт, шинэчлэлийг хийх, нөгөө талаас эмч, эмнэлгийн ажилчдын сэтгэл ханамж, эрэлт хэрэгцээг харьцуулан судлах нь чухал юм.

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь 2004 оноос “Эрүүл мэндийн байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх” ажлын нэг үзүүлэлт болгон Эрүүл мэнд, спортын яамны (ЭМСЯ)-ны харьяа эрүүл мэндийн байгууллагуудад жилд нэг удаа, нэгдсэн зохион байгуулалттайгаар сэтгэл ханамжийн судалгааг хийж байна.

Энэхүү 14 жилийн хугацаанд судалгааны аргачлал, асуулгыг тогтмол сайжруулан, улмаар Эрүүл мэндийн сайдын 2014 оны 01 сарын 13-ны өдрийн 13 тоот тушаалаар судалгааны аргачлалыг батлуулсан.

2015 онд энэхүү аргачлал, асуулгын дагуу, зарим нэг нэмэлт хэмжигдэхүүнийг оруулан, хэрэглэгчийн судалгааны түүврийн тоог шинэчлэн, судалгаа хийлээ.

**Зорилго:** Эрүүл мэндийн байгууллагуудын Хэрэглэгч-Үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжийг судлан, шийдвэр гаргагчдыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах.

### Зорилт:

- Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийг судлах
- Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийг судлах
- Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх түвшинд нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргахад мэдээллээр хангах

### Үр дүн:

- Хэрэглэгч-Эмч, эмч ажилтны сэтгэл ханамжийг тодорхойлсон судалгааны үр дүнгийн тайлан бичигдэнэ.
- Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх түвшинд нотолгоогоор хангагдана.

## ХОЁР. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

**Судалгааны аргачлал:** Судалгааг тоон судалгааны аргаар тусгайлан боловсруулсан 50-65 хувьсах ба үл хувьсах хэмжигдэхүүн бүхий 2 төрлийн асуумжаар, өөрсдөөр нь бөглүүлэх аргаар явуулав. Судалгааны асуулгад 2 асуудлыг нээлттэй бөглөхөөр оруулсан болно.

**Судалгааны хамрах хүрээ:** ЭМСЯ-ны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийг зориудаар сонгов.

**Судалгааны нэгж, түүвэрлэлтийн тоо:** Судалгааны нэгж нь эрүүл мэндийн байгууллагуудын амбулатор болон стационариар тухайн агшинд үйлчлүүлж байсан хэрэглэгч, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд байв. Судалгааны түүвэрлэлтийн тоог тогтоохдоо хэрэглэгчийн хувьд тухайн байгууллагын хэвтэн эмчлүүлэх орны тоог эх олонлогоор авч, түүврийн тоог дараах томъёогоор байгууллага бүрээр тооцоолон тогтоосон бөгөөд энэхүү түүвэрлэлт нь 95.4%-ийн үнэн магадлалыг хангана.

$$n = \frac{t^2 \cdot w(1-w) \cdot N}{N \cdot \Delta_p^2 + t^2 \cdot w(1-w)}$$

- ❖ *t-баталгааны коэффициентийг 95.4 хувийн үнэн магадлалтай байхаар  $t = 2$  авлаа.*
- ❖  *$w(1-w)$ - дунджаас хазайх хазайлтын квадрат буюу дисперсийг 0.25-аар тооцоолов.*
- ❖ *N- эх олонлогийн хэмжээ*
- ❖ *Дельта- Алдааны хязгаар ба 0.05 аар авлаа.*
- ❖ *n- түүврийн хэмжээ болно.*

Эмч, ажилчдын хувьд судалгааны цаг хугацаа, эх олонлогийн тооноос хамааран 50-аас доош хүнтэй бол бага түүвэр, 100-аас дээш хүнтэй бол багахан хэмжээний түүвэр гэж үзсэн. Үүний дагуу бага түүврийг 90-95%, багахан хэмжээний түүврийг 20% хувиар тооцоолон, үнэн магадлалыг хангахын тулд мужилсан түүврийн аргыг сонгосон.

Тухайлбал: Мужилсан түүврийн аргаар, тухайн байгууллагад ажиллаж байгаа нийт эмч, бусад дээд мэргэжилтний 20.0%, сувилагч тусгай мэргэжилтний 20.0%, бусад ажилтны 20.0%-ыг түүврийн тоогоор тогтоосон.

Аргачлалын дагуу тухайн өдөр, тухайн агшинд ажиллаж буй эмч, ажилчдаас энгийн, санамсаргүй аргаар судалгаанд хамруулав.

**ЭМСЯ-ны харьяа байгууллагуудын түүвэрлэлтийн тоо**

№	Эмнэлгийн нэр	Хэрэглэгчийн түүвэр		Эмч, ажилчдын түүвэр					Нийт Түүвэр
		Орны тоо	Түүвэр	Нийт ажилтан	Эмч, бусад дээд	Сувилагч бусад	Бусад ажилчид	Түүвэр	
1	ЭХЭМҮТ	658	219	1055	53	103	50	183	402
2	УНТЭ	544	228	707	42	66	36	138	366
3	УХТЭ	530	118	759	21	32	29	74	192
4	УГТЭ	450	187	434	39	56	36	127	314
5	ХСҮТ	412	126	535	28	32	24	82	208
6	ХӨСҮТ	430	194	662	50	54	44	144	338
7	ГССҮТ	195	204	402	25	43	33	97	301
8	АӨСҮТ	190	116	431	11	8	9	26	142
9	СЭМҮТ	170	70	143	20	22	40	89	159
10	ЗӨСҮТ	90	-	113	12	3	5	20	20
11	ГҮТ	-	30	37	12	2	6	18	18
12	ХТС	-	-	104	22	8	9	33	33
3	ЦССҮТ	-	-	59	18	26	8	45	45
14	ЭСҮТ	-	-	56	30	17	7	37	37
15	НЭМҮТ	-	-	90	25	15	14	54	54
<b>Нийт</b>		<b>3669</b>	<b>1492</b>	<b>5587</b>	<b>408</b>	<b>487</b>	<b>350</b>	<b>1167</b>	<b>2629</b>

**Судалгааны мэдээлэл цуглуулах хэрэгсэл (асуумж карт):**

- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн асуумж - 8 бүлэг 50 хувьсах хэмжигдэхүүн, 2 нээлттэй асуумж, 3 үл хувьсах хэмжигдэхүүн бүхий асуулга
- Эмч, эмнэлгийн ажилчдийн сэтгэл ханамжийн асуумж - 9 бүлэг 60 хувьсах хэмжигдэхүүн, 2 нээлттэй асуулт, 5 үл хувьсах хэмжигдэхүүн бүхий асуулга

**Мэдээ, мэдээллийг боловсруулах:** Мэдээллийг SPSS-20.0 болон Excel програмуудыг ашиглан дескриптив ба статистикийн энгийн шинжилгээний аргыг ашиглан, үр дүнгийн шинжилгээ хийсэн.

Сэтгэл ханамжийн түвшинг илэрхийлэх 2 үзүүлэлтийг тооцон гаргасан. Үүнд:

1. Сэтгэл ханамжийн түвшин (балл болон хувиар)
  - Эрүүл мэндийн байгууллага бүрээр
  - Үзүүлэлт бүрээр
2. Тухайн хариултын (“сайн”, “дунд”, “муу”) эзлэх хувь
  - Эрүүл мэндийн байгууллага бүрээр
  - Үзүүлэлт бүрээр

Сэтгэл ханамжийн түвшинг балл болон хувиар илэрхийлэхдээ Эрүүл мэндийн сайдын 2014 оны 6/182 тушаалд заасны дагуу “сайн”, “дунд”, “муу” гэсэн хариултуудад хүснэгтэд заасан харгалзах оноо/балл өгөн дундаж баллыг олж, тухайн дундаж баллыг хувьд шилжүүлэн тооцсон.

Дундаж баллыг хувьд шилжүүлэхдээ: Тухайн үзүүлэлтийн сэтгэл ханамжийн хувь = 0% + (3 – Тухайн үзүүлэлтийн дундаж оноо)\*50% томъёогоор шилжүүлэн бодсон болно. Үүнд:

0% – Сэтгэл ханамж муу буюу 3 гэсэн оноонд харгалзах хувь

3 – Сэтгэл ханамж муу гэсэн хариултад харгалзах оноо

50% – 1-3 гэсэн онооны 1 бүхэл интервалд ноогдох хувь (тогтмол тоо)

Үзүүлэлт	Сайн	Дунд	Муу
Сэтгэл ханамжийн оноо/балл	1	2	3
Сэтгэл ханамжийн түвшин (хувиар)	<b>66.8-100</b>	<b>33.4-66.7</b>	<b>0-33.3</b>

Харин тухайн хариултын (“сайн”, “дунд”, “муу”) эзлэх хувийг тооцохдоо тухайн эрүүл мэндийн байгууллагаар болон үзүүлэлтийн нийт хариултад тухайн хариултын эзлэх хувиар тооцсон болно.

**Судалгааны ажлын хүн хүчин:** Судалгааны мэдээлэл цуглуулах багт Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Тогтолцооны судалгаа, статистикийн хэлтсийн мэргэжилтэн Э.Ундармаа, Ц.Мөнх-Од, Б.Доржмягмар, П.Эрхэмбаяр, резидент эмч Э.Баярбат, Л.Жаргалтогтох, Я.Оюу-Эрдэнэ, Б.Ууганцэцэг, С.Саранбаатар, З.Нарангэрэл, Д.Мөнхбат нар ажиллан, мэдээллийг тус хэлтсийн мэргэжилтэн Т.Өнөрцэцэг, Э.Ундармаа боловсруулан, үр дүнгийн тайланг ахлах мэргэжилтэн Л.Ширнэн бичлээ.

**Мэдээллийг түгээх:** Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн тайланг ЭМСЯ-ны харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны жилийн гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ, үнэлгээнд ашиглана. Судалгааны үр дүнг шийдвэр гаргагч, хэрэглэгчдэд нээлттэй мэдээлнэ.

## ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

### БҮЛЭГ 1. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Судалгаанд түүврийн хийсэн аргачлалын дагуу, ЭМСЯ-ны харьяа 3 төв эмнэлэг, 6 тусгай мэргэжлийн төв, НЭМҮТ, нийт 15 байгууллагаар үйлчлүүлсэн 1492 хэрэглэгч, 1167 эмч, эмнэлгийн ажилтан, нийт 2629 хүн хамрагдсан.

Хэрэглэгчийн судалгааг ортой төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдээс 95.4%-ийн үнэн магадтай байдлыг ханган, хэвтэн эмчлүүлж байгаа болон тухайн агшинд үйлчлүүлж байгаа иргэдээс санамсаргүй энгийн аргаар, тасаг, нэгж бүрийг жигд хамруулан авсан.

СЭМҮТ-ийн тусламж, үйлчилгээний онцлогоос хамааран, орны тоогоор түүвэрлэлтийн тоог тогтоолгүй, мэдрэлийн тасгаар үйлчлүүлж байгаа болон, амбулаториор зөвлөгөө авч буй хэрэглэгчдээс судалгаа авсан. Мөн ГҮТ нь оргүй боловч, амбулаторын үйлчилгээ үзүүлдэг учраас тухайн өдөр үйлчлүүлсэн 30 хүнээс судалгаа авлаа.

**Хүснэгт 1. Хэрэглэгчийн нас, хүйсийн бүтэц, үйлчлүүлсэн байдал**

№	Эмнэлгийн нэр	Хүйс		Үйлчлүүлэгчийн нас						Үйлчлүүлсэн тоо	
		эр	эм	15-19	20-29	30-39	40-49	50-59	60+	Анх удаа	2 ба түүнээс дээш удаа
1	ЭХЭМҮТ	10.9%	89.1%	5.4%	29.1%	24.4%	38.1%	0.0%	0.0%	67.6%	32.4%
2	УНТЭ	48.7%	51.3%	0.0%	15.0%	35.6%	31.1%	13.3%	5.0%	58.8%	41.2%
3	УХТЭ	29.9%	70.1%	0%	14.10%	33%	12.90%	27.10%	12.90%	38.6%	61.4%
4	УГТЭ	42.0%	58.0%	3.10%	30.70%	16.50%	18.90%	15.00%	15.70%	57.6%	42.4%
5	ХСҮТ	28.8%	71.2%	0%	14.70%	16.20%	23.60%	30.80%	14.70%	64.0%	36.0%
6	ХӨСҮТ	49.4%	50.6%	0%	29.10%	38.40%	21.50%	8.10%	2.90%	77.4%	22.6%
7	ГССҮТ	51.3%	48.7%	0%	16.50%	28.20%	30.20%	21.20%	3.80%	67.7%	32.3%
8	АӨСҮТ	45.7%	54.3%	5.10%	22.30%	35.40%	15.20%	22.00%	0	50.0%	50.0%
9	СЭМҮТ	35.3%	64.7%	0%	19.40%	29.90%	34.30%	16.40%	0	42.9%	57.1%
10	ГҮТ	23.1%	76.9%	0%	0%	0%	0%			32.0%	68.0%

Судалгаанд хамрагдсан хэрэглэгчийн 36.5% эрэгтэйчүүд, 63.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Насны бүлгээр авч үзвэл 15-19 насныхан 4.5%, 20-29 насныхан 19.0%, 30-39 насныхан 24.2%, 40-49 насныхан 22.2%, 50-59 насныхан 19.0%, 60 ба дээш насныхан 11.5% байна.

Тэдний 60.6 хувь нь тухайн эмнэлгээр анх удаа үйлчлүүлж байгаа 39.4% нь 2 ба түүнээс дээш удаа үйлчлүүлсэн хүмүүс байна.


Байгууллагаар авч үзвэл УХТЭ, ГҮТ, СЭМҮТ, АӨСҮТ-өөр 2 ба түүнээс дээш үзүүлсэн хэрэглэгч 50.0 ба түүнээс дээш, өөрөөр хэлбэл давтан үзлэгийн хувь дийлэнх нь байна.

ЭХЭМҮТ, ХСҮТ, ХӨСҮТ, УНТЭ, УГТЭ, ГССҮТ-ийн хэрэглэгчийн 58.8% ба түүнээс дээш хувиар анх удаа тухайн эмнэлгээр үйлчлүүлэгчдэд байна.

**Хүснэгт 2. Эмч, эмнэлгийн ажилчдын нас, хүйсийн бүтэц, ажилласан жил**

Эмнэлгийн нэр	Хүйс		Нас							Ажилласан жил				
	эрэгтэй	эмэгтэй	20-25	26-30	31-35	36-40	41-45	46-49	50-55	1-5	6-10	11-15	16-20	21-25
ЭХЭМҮТ	13.1%	86.9%	23.1%	25.4%	40.2%	10.7%	0.6%	0.0%	0.0%	61.7%	19.1%	18.6%	0.0%	0.5%
УНТЭ	26.1%	73.9%	24.6%	47.1%	23.9%	4.3%	0.0%	0.0%	0.0%	72.5%	18.1%	9.4%	0.0%	0.0%
УХТЭ	27.0%	73.0%	30.0%	21.7%	35.0%	13.3%	0.0%	0.0%	0.0%	59.5%	27.0%	13.5%	0.0%	0.0%
УГТЭ	23.5%	76.5%	0.0%	99.2%	0.0%	0.8%	0.0%	0.0%	0.0%	39.8%	31.0%	12.4%	9.7%	7.1%
ХСҮТ	15.9%	84.1%	29.3%	23.2%	19.5%	25.6%	2.4%	0.0%	0.0%	58.5%	23.2%	18.3%	0.0%	0.0%
ХӨСҮТ	17.6%	82.4%	7.9%	18.1%	19.7%	8.7%	16.5%	9.4%	19.7%	36.4%	23.6%	9.1%	15.5%	15.5%
ГССҮТ	40.2%	59.8%	31.3%	27.1%	30.2%	8.3%	3.1%	0.0%	0.0%	75.8%	12.6%	10.5%	1.1%	0.0%
АӨСҮТ	7.7%	92.3%	20.0%	28.0%	40.0%	12.0%	0.0%	0.0%	0.0%	53.8%	34.6%	11.5%	0.0%	0.0%
СЭМҮТ	14.9%	85.1%	7.4%	22.2%	18.5%	13.6%	25.9%	6.2%	6.2%	39.7%	28.6%	17.5%	6.3%	7.9%
ЗӨСҮТ	21.1%	78.9%	6.3%	25.0%	18.8%	18.8%	12.5%	6.3%	12.5%	41.2%	35.3%	5.9%	17.6%	0.0%
ГҮТ	35.3%	64.7%	58.8%	17.6%	11.8%	11.8%	0.0%	0.0%	0.0%	66.7%	22.2%	11.1%	0.0%	0.0%
ХТС	21.2%	78.8%	21.2%	12.1%	36.4%	30.3%	0.0%	0.0%	0.0%	75.8%	24.2%	0.0%	0.0%	0.0%
ЦССҮТ	24.3%	75.7%	43.3%	26.7%	20.0%	10.0%	0.0%	0.0%	0.0%	73.3%	20.0%	6.7%	0.0%	0.0%
УСҮТ	12.9%	87.1%	0.0%	30.0%	13.3%	13.3%	16.7%	13.3%	13.3%	44.4%	11.1%	27.8%	5.6%	11.1%
НЭМҮТ	31.5%	68.5%	38.9%	22.2%	25.9%	9.3%	3.7%	0.0%	0.0%	77.4%	17.0%	3.8%	1.9%	0.0%
Нийт	21.7%	78.3%	20.1%	35.0%	23.8%	10.5%	5.3%	2.0%	3.3%	58.7%	22.2%	12.5%	3.6%	3.1%

**Зураг 1. Эмч, эмнэлгийн ажилтны хүйс, нас, ажилласан жилийн дундаж үзүүлэлт**



Судалгаанд хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны 21.7 хувь нь эрэгтэйчүүд, 78.3 хувь нь эмэгтэйчүүд эзэлж, насны бүлгээр авч үзвэл 20-25 насныхан 20.1%, 26-30 насныхан 35.0%, 31-35 насныхан 23.8%, 36-40 насныхан 10.5%, 41-45 насныхан 5.3%, 46-49 насныхан 2.0%, 50-55 насныхан 3.3%-ийг тус тус эзэлж байгаа ба 20-35 насны залуу ажиллах хүчин түлхүү судалгаанд хамрагдсан байна.

Тухайн байгуулагадаа ажилласан жилээр авч үзвэл 1-5 жил ажилласан 58.7%, 6-10 жил ажилласан 22.2%, 11-15 жил ажилласан 12.5%, 16-20 жил ажилласан 3.6%, 21-25 жил ажилласан 3.1% байгаа нь настай шууд хамааралтай байна.

**Бүлгийн дүгнэлт:** Судалгаанд 1492 хэрэглэгч, 1167 эмч, эмнэлгийн ажилтан, нийт 2629 хүн хамрагдсан. Эмч, эмнэлгийн ажилтны дийлэнх нь 20-35 насны залуучууд, хэрэглэгчийн дийлэнх нь 30-60 насныхан байна.


## БҮЛЭГ 2. БАЙГУУЛЛАГЫН СЭТГЭЛД НИЙЦСЭН ҮЙЛЧИЛГЭЭ, СОЁЛ

Эрүүл мэндийн салбарын суурь шинэчлэлийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагууд 2013 оноос сэтгэлд нийцсэн үйлчилгээг нэвтрүүлж байна. Байгууллагын сэтгэлд нийцсэн үйлчилгээ, соёлын талаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийг 11 хэмжигдэхүүнээр, эмч, ажилчдын сэтгэл ханамжийг 12 хэмжигдэхүүнээр тодорхойлсон ба Үйлчлүүлэгч-Үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжийг харьцуулан судлах үүднээс хэмжигдэхүүнийг ижил авч, онцлох хэмжигдэхүүнийг нэмэлтээр оруулсан болно.

Бүх бүлэгт сэтгэл ханамжтай байдлыг байгууллага бүрээр харьцуулан авч үзэхдээ “сайн” гэсэн үнэлгээний хувиар илэрхийлэн, зургаар харуулсан. *Сэтгэл ханамжийн түвшин нь* судалгаанд хамрагчдын баллын үнэлгээнд суурилсан дундаж үзүүлэлт болно.

“Инээмсэглэн угтаж, мэндлэх, хүндлэх үйлчилгээ”-нд Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 86.5%-тай байгаа бол Үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.4%-тай, 3.9%-ийн зөрөөтэй байна.


Зураг 2. Инээмсэглэн угтаж, мэндлэх, хүндлэх үйлчилгээний сэтгэл ханамж



“Инээмсэглэн угтаж, мэндлэх, хүндлэх үйлчилгээ”-нд хэрэглэгчид 58.4%-100.0% “сайн” гэсэн үнэлгээ өгсөн бол эмч, ажилтан 70.1-100.0 байна. Үнэлгээнээс харахад ЭХЭМҮТ-ийн хэрэглэгчид хамгийн бага сэтгэл ханамжтай, хоорондын зөрөө ихтэй байна. Харин УХТЭ, СЭМҮТ-д хэрэглэгчид, үйлчилгээ үзүүлэгчдээс буюу өөрсдөөс нь илүү сэтгэл ханамж сайтай байна.

“Бүртгэх, лавлагаа мэдээлэл өгөх, танилцуулах үйлчилгээ”-нд Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 87.6% байгаа бол Үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 91.5%-тай, 3.9%-ийн зөрөөтэй байна.


Зураг 3. Бүртгэх, лавлагаа мэдээлэл өгөх, танилцуулах үйлчилгээний сэтгэл ханамж



Бүртгэх, лавлагаа мэдээлэл өгөх, үйл ажиллагаагаа танилцуулах үйлчилгээнд хэрэглэгчид 63.0%-100.0% “сайн” гэж үнэлсэн, эмч, ажилтан 67.0-100.0% байна. Харин УХТЭ, ГССҮТ, ХӨСҮТ-ийн хэрэглэгчид өөрсдөөс нь илүү сэтгэл ханамж сайн байна.

“Сэтгэлд нийцсэн зөвлөх үйлчилгээ”-нд Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 88.8% байгаа бол Үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 91.6%-тай, 2.8%-ийн зөрөөтэй байна.


Зураг 4. Сэтгэлд нийцсэн зөвлөх үйлчилгээний сэтгэл ханамж



Сэтгэлд нийцсэн зөвлөх үйлчилгээнд хэрэглэгчид 68.5%-100.0% нь сайн үнэлгээ өгсөн, эмч, ажилтан 67.0-100.0% сэтгэл ханамжтай байна. ХСҮТ, ЭХЭМҮТ-ийн эмч, ажилтны өөрсдийгөө үнэлсэн үнэлгээ хэрэглэгчдээсээ харьцангуй өндөр хувьтай байна.

“Сэтгэлд нийцсэн оношлох үйлчилгээ”-нд Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 88.8% байгаа бол Үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 91.6%-тай, 2.8%-ийн зөрөөтэй байна.


Зураг 5. Сэтгэлд нийцсэн оношлох үйлчилгээний сэтгэл ханамж



Сэтгэлд нийцсэн зөвлөх үйлчилгээнд хэрэглэгчид 81.4%-100.0% сэтгэл ханамжтай, эмч, ажилтан 68.0-100.0% сэтгэл ханамжтай байна. Оношлох үйлчилгээний сэтгэл ханамжтай буюу сайн гэсэн үнэлгээ харьцангуй ойролцоо түвшинд байгаа боловч, байгууллага бүрээр авч үзвэл ГССҮТ, СЭМҮТ, ХӨСҮТ, УХТЭ, УГТЭ-т давамгайл байдал харагдаж байна.

“Сэтгэлд нийцсэн эмчлэх үйлчилгээ”-нд Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 93.1% байгаа бол Үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 93.2%-тай ижил түвшинд байна.


Зураг 6. Сэтгэлд нийцсэн эмчлэх үйлчилгээний сэтгэл ханамж



Сэтгэлд нийцсэн эмчлэн үйлчилгээнд хэрэглэгчийн сэтгэл ханамж жигд “сайн” буюу 82.6-100.0 сэтгэл ханамжтай байдал харагдаж байна. Эмчлэх үйлчилгээндээ эмч, ажилтан өөрсдөө сэтгэл ханамж бага, тухайлбал, ГССҮТ-ийн 74.2% сэтгэл ханамжтайгаа илэрхийлсэн бол тэдний үйлчлүүлэгчид 7.2%-иар илүү сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн дүр зураг харагдаж байна. Мөн энэ жишээнд УХТЭ, ХӨСҮТ-ийг дурдаж болохоор байна.

“Сэтгэлд нийцсэн сувилах, асрах үйлчилгээ”-нд Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 91.4% байгаа бол Үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 92.5%-тай, ойролцоо түвшинд байна.


Зураг 7. Сэтгэлд нийцсэн сувилах, асрах үйлчилгээний сэтгэл ханамж



Сэтгэлд нийцсэн сувилах, асрах үйлчилгээнд хэрэглэгчид 77.6-100.0%-ийн сэтгэл ханамжтай, эмч, ажилтан 73.2-100.0%-ийн сэтгэл ханамжтай байна. Харьцуулан авч үзвэл УХТЭ, УГТЭ, ХӨСҮТ, ГССҮТ, СЭМҮТ-ийн хэрэглэгчид эмч, ажилтнаас сэтгэл ханамж илүү байна.

“Байгууллагын дотоод орчны тав, тух соёл”-д хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 87.1%, үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 86.7%-тай, ойролцоо түвшинд байна.


Зураг 8. Байгууллагын дотоод орчны тав тух соёлын талаарх сэтгэл ханамж



“Байгууллагын дотоод орчны тав, тух соёл”-д хэрэглэгчид 77.6-100.0%-ийн сэтгэл ханамжтай, эмч, ажилтан 73.2-100.0%-ийн сэтгэл ханамжтай байна. Дотоод орчны тав тухтай байдалд ГССҮТ-ийн хэрэглэгч болон эмч, ажилтан хамгийн сэтгэл ханамж багатай байгаа бол СЭМҮТ хамгийн өндөр байна. УХТЭ-т хамгийн их зөрөөтэй байдал харагдаж байна.

“Байгууллагын гадаад орчны тав, тух соёл”-д хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 83.4%, үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 82.3%-тай, ойролцоо түвшинд байна.


**Зураг 9. Байгууллагын гадаад орчны тав тух соёлын талаарх сэтгэл ханамж**



“Байгууллагын гадаад орчны тав, тух соёл”-д хэрэглэгчид 60.3-85.7%-ийн сэтгэл ханамжтай, эмч, ажилтан 45.4-100.0%-ийн сэтгэл ханамжтай байна. Гадаад орчны тав тухтай байдалд ХӨСҮТ, ГССҮТ-ийн хэрэглэгч болон эмч, ажилтан хамгийн сэтгэл ханамж бага байна. ХСҮТ, АӨСҮТ-т зөрөөтэй байдал илүү байна.

“Эмч, эмнэлгийн мэргэжилтний хувцаслалтын соёл, таних тэмдэг” талаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 94.3%, үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.1%-тай, 3.2%-ын зөрөөтэй байна.


**Зураг 10. Эмч, эмнэлгийн мэргэжилтний хувцаслалтын соёл, таних тэмдгийн талаарх сэтгэл ханамж**



Эмч, эмнэлгийн мэргэжилтний хувцаслалтын соёл, таних тэмдгийн талаар хэрэглэгчид 85.3-100.0%-ийн сэтгэл ханамжтай, эмч, ажилтан 71.1-100.0%-ийн сэтгэл ханамжтай байна. Энэ талаар дийлэнх байгууллагын хэрэглэгчид, эмч ажилтнаас сэтгэл ханамж өндөр, эмч ажилтан бага байгаа нь харагдлаа.

“Хүнд өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх үйлчилгээ”-нд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 91.0%, үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.5%-тай, ойролцоо түвшинд байна.

**Зураг 11. Хүнд өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх үйлчилгээний сэтгэл ханамж**






“Хүнд өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх үйлчилгээ”-нд хэрэглэгчид 76.0-96.7%-ийн сэтгэл ханамжтай, эмч, ажилтан 76.0-96.7%-ийн сэтгэл ханамжтай байна. Сэтгэл ханамжтай байдал УГТЭ, ХСҮТ, ХӨСҮТ, ГССҮТ, АӨСҮТ, СЭМҮТ, ГҮТ гэсэн 7 байгууллагад ижил түвшинд байгаа нь үнэлгээ нилээн бодитой байгааг харуулж байна.

Энэ бүлэгт бид эмч, ажилтнаас байгууллагын соёл, үнэт зүйлийн нэг чухал үзүүлэлт байгууллагынхаа стратегийн алсын хараа, эрхэм, зорилгыг ажилтан бүр мэддэг, хэрэгжилтийг хангаж ажилладаг байдал болон байгууллагаараа бахархах байдлыг тусгайлан асуусан.

Эмч, ажилчдын байгууллагынхаа стратегийн алсын хараа, эрхэм, зорилгыг ажилтан бүр мэддэг, хэрэгжилтийг хангаж ажилладаг талаар 90.4%-ийн сэтгэл ханамжийн түвшинтэй байгаа бол байгууллагаараа бахархах сэтгэл ханамжийн түвшин 93.1%-тай байна.

Зураг 12. Эмч, ажилтны байгууллагаараа бахархах сэтгэл, алсын хараа, эрхэм зорилго, стратегийг мэддэг байдал



Байгууллагынхаа алсын хараа, эрхэм зорилго, стратегийг ажилтан бүр мэддэг, хэрэгжүүлж ажилладаг гэдэгт УХТЭ, ГССҮТ, ЗӨСҮТ, ЭСҮТ-ийн эмч ажилтны цөөнгүй хувь нь эргэлзсэн, 60.0-66.2% нь сэтгэл ханамжтай” гэж үзжээ.

### ХҮСНЭГТ 3. БАЙГУУЛЛАГЫН СЭТГЭЛД НИЙЦСЭН ҮЙЛЧИЛГЭЭ, СОЁЛ

Хүснэгт 3.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны сэтгэл ханамж

Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, стратегийг ажилтан бүр мэддэг, хэрэгжилтийг хангаж ажилладаг	Инэмсэглэн утах, мөндлөх, хүндлэх үйлчилгээ			Бүртгэх, лавлагаа мэдээлэл өгөх, танилцуулах үйлчилгээ			Сэтгэлд нийцсэн зөвлөх үйлчилгээ			Сэтгэлд нийцсэн оюулох үйлчилгээ			Сэтгэлд нийцсэн эмчлэх үйлчилгээ			Сэтгэлд нийцсэн сувилал, асрах үйлчилгээ			Байгууллагын дотоод орчны тав тух, соёл			Байгууллагын гадаад орчны тав тух, соёл			Эмч, мэргэжилтний хувцаслалтын соёл, таних тэмдэг			Хүнд өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх үйлчилгээ			Байгууллагаараа бахархах сэтгэл		Бүтлийн дундаж				
	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	балл	хувь		
91.8	8.2	0.0	74.3	24.6	1.1	79.8	19.1	1.1	80.9	18.0	1.1	83.6	16.4	0.0	87.4	12.6	0.0	86.9	13.1	0.0	80.3	18.0	1.6	76.0	21.9	2.2	89.6	9.8	0.5	79.8	18.0	2.2	93.4	6.6	0.0	1.17	91.6
80.4	17.4	2.2	82.6	15.9	1.4	90.6	8.7	0.7	87.0	11.6	1.4	89.1	10.1	0.7	92.0	8.0	0.0	87.7	10.9	1.4	84.1	13.8	2.2	75.4	20.3	4.3	83.3	14.5	2.2	85.5	12.3	2.2	92.8	5.8	1.4	1.15	92.3
66.2	29.7	4.1	79.7	17.6	2.7	77.0	17.6	5.4	74.3	21.6	4.1	78.4	20.3	1.4	75.7	23.0	1.4	82.4	17.6	0.0	66.2	29.7	4.1	62.2	31.1	6.8	83.8	16.2	0.0	75.7	18.9	5.4	86.5	13.5	0.0	1.26	86.9
83.5	15.0	1.6	86.8	14.2	0.0	86.6	12.6	0.8	84.3	15.7	0.0	84.3	15.0	0.8	85.0	15.0	0.0	81.1	18.9	0.0	78.0	21.3	0.8	65.4	27.6	7.1	72.4	25.2	2.4	81.9	15.0	3.1	92.9	7.1	0.0	1.19	90.4
92.7	7.3	0.0	93.9	6.1	0.0	96.3	3.7	0.0	96.8	3.7	0.0	96.8	3.7	0.0	97.6	2.4	0.0	98.8	1.2	0.0	89.0	11.0	0.0	92.7	6.1	1.2	96.3	3.7	0.0	90.0	10.0	0.0	100.0	0.0	0.0	1.04	97.8
77.8	21.5	0.7	77.8	21.5	0.7	77.8	21.5	0.7	81.3	17.4	1.4	84.7	14.6	0.7	81.3	18.1	0.7	81.9	17.4	0.7	63.2	31.9	4.9	55.6	39.6	4.9	71.5	27.1	1.4	72.2	25.7	2.1	81.3	18.8	0.0	1.26	87.0
64.9	34.0	1.0	63.9	35.1	1.0	67.0	29.9	3.1	67.0	32.0	1.0	68.0	30.9	1.0	74.2	25.8	0.0	73.2	25.8	1.0	56.7	36.1	7.2	45.4	43.3	11.3	71.1	24.7	4.1	67.0	25.8	7.2	79.4	18.6	2.1	1.37	81.6
96.2	0.0	3.8	96.2	3.8	0.0	92.3	3.8	3.8	96.2	0.0	3.8	96.2	0.0	3.8	92.3	7.7	0.0	92.3	3.8	3.8	92.3	7.7	0.0	84.6	15.4	0.0	88.5	7.7	3.8	92.3	7.7	0.0	110	95.1			
87.6	12.4	0.0	87.6	12.4	0.0	94.4	5.6	0.0	95.5	4.5	0.0	91.0	9.0	0.0	93.3	6.7	0.0	92.1	7.9	0.0	85.4	14.6	0.0	73.0	24.7	2.2	89.9	10.1	0.0	78.7	20.2	1.1	94.4	5.6	0.0	1.11	94.3
60.0	40.0	0.0	40.0	55.0	5.0	65.0	25.0	10.0	55.0	45.0	0.0	70.0	30.0	0.0	70.0	30.0	0.0	65.0	35.0	0.0	50.0	50.0	0.0	50.0	50.0	0.0	35.0	65.0	0.0	70.0	30.0	0.0	65.0	30.0	5.0	1.42	78.8
100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	77.8	22.2	0.0	61.1	38.9	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	1.05	97.6
90.9	9.1	0.0	97.0	3.0	0.0	97.0	3.0	0.0	93.9	6.1	0.0	97.0	3.0	0.0	97.0	3.0	0.0	97.0	3.0	0.0	97.0	3.0	0.0	90.9	9.1	0.0	97.0	3.0	0.0	97.0	3.0	0.0	97.0	3.0	0.0	1.04	97.9
88.9	6.7	4.4	86.7	11.1	2.2	93.3	4.4	2.2	88.9	8.9	2.2	86.7	11.1	2.2	88.9	8.9	2.2	86.7	11.1	2.2	77.8	20.0	2.2	80.0	17.8	2.2	88.9	6.7	4.4	77.8	15.6	6.7	91.1	6.7	2.2	1.16	91.9
62.2	29.7	8.1	75.7	21.6	2.7	83.8	8.1	8.1	83.8	16.2	0.0	89.2	10.8	0.0	86.5	10.8	2.7	70.3	21.6	8.1	43.2	45.9	10.8	37.8	51.4	10.8	62.2	32.4	5.4	67.6	24.3	8.1	70.3	24.3	5.4	1.36	81.8
90.7	9.3	0.0	85.2	14.8	0.0	90.7	9.3	0.0	92.6	7.4	0.0	92.6	7.4	0.0	94.4	5.6	0.0	94.4	5.6	0.0	90.7	9.3	0.0	81.5	14.8	3.7	87.0	13.0	0.0	94.4	3.7	1.9	94.4	5.6	0.0	1.10	94.9
1.19			1.20			1.17			1.17			1.15			1.14			1.15			1.27			1.35			1.20			1.10			1.14			1.19	
90.4			89.9			91.5			91.6			92.6			93.2			92.5			86.7			82.3			90.1			95.0			93.1			90.5	


Хүснэгт 3.2. Хэрэглэгчийн сэтгэл ханамж

Эмнэлгийн нэр	n	Инэмсэглэн утах, мөндлөх, хүндлэх үйлчилгээ			Бүртгэх, лавлагаа мэдээлэл өгөх, үйл ажиллагаа танилцуулах үйлчилгээ			Сэтгэлд нийцсэн зөвлөх үйлчилгээ			Сэтгэлд нийцсэн оюулох үйлчилгээ			Сэтгэлд нийцсэн эмчлэх үйлчилгээ			Сэтгэлд нийцсэн сувилал, асрах үйлчилгээ			Байгууллагын дотоод орчны тав тух, соёл			Байгууллагын гадаад орчны тав тух, соёл			Эмч, мэргэжилтний хувцаслалтын соёл, таних тэмдэг			Хүнд өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх үйлчилгээ			Бүтлийн дундаж				
		Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	балл	хувь			
ЭХЭМҮТ	219	58.4	31.1	10.5	63.0	31.5	5.5	68.5	27.4	4.1	83.6	16.0	0.5	82.6	15.5	1.8	77.6	20.1	2.3	74.0	22.4	3.7	67.1	25.6	7.3	88.1	11.4	0.5	84.0	14.2	1.8	1.29	85.5			
УНТЭ	228	78.9	18.4	2.6	80.7	18.4	0.9	83.8	14.5	1.8	88.2	11.0	0.9	91.2	8.3	0.4	85.1	13.2	1.8	77.6	18.4	3.9	71.1	24.1	4.8	85.1	14.0	0.9	82.0	18.0	0.0	1.19	90.3			
УХТЭ	118	85.6	12.7	1.7	81.4	16.9	1.7	84.7	12.7	2.5	83.1	11.0	5.9	87.3	11.9	0.8	89.8	7.6	2.5	81.4	16.1	2.5	74.6	22.9	2.5	90.7	5.9	3.4	87.3	11.9	0.8	1.18	91.1			
УГТЭ	187	80.2	18.2	1.6	80.2	16.6	3.2	82.9	15.5	1.6	85.6	12.3	2.1	86.1	12.3	1.6	86.6	13.4	1.1	84.0	14.4	1.6	73.8	24.1	2.1	90.9	8.0	1.1	83.4	14.4	2.1	1.19	90.7			
ХСҮТ	126	83.3	12.7	4.0	81.0	15.1	4.0	81.0	15.1	4.0	84.9	10.3	4.8	88.1	11.1	0.8	82.5	15.9	1.6	77.8	19.0	3.2	78.6	20.6	0.8	94.4	5.6	0.0	84.1	11.9	4.0	1.20	90.2			
ХӨСҮТ	194	74.2	24.2	1.5	78.9	20.1	1.0	79.9	19.6	0.5	86.6	13.4	0.0	86.1	13.9	0.0	86.1	12.9	1.0	75.8	20.6	3.6	66.5	27.8	5.7	89.2	10.8	0.0	83.0	16.0	1.0	1.21	89.6			
ГССҮТ	204	70.1	26.5	3.4	69.1	28.4	2.5	72.5	25.5	2.0	81.4	18.1	0.5	81.4	17.6	1.0	77.9	20.1	2.0	62.7	33.3	3.9	60.3	33.8	5.9	85.3	13.7	1.0	76.0	21.6	2.5	1.29	85.6			
АӨСҮТ	116	83.6	16.4	0.0	87.9	11.2	0.9	87.1	11.2	1.7	89.7	9.5	0.9	91.4	8.6	0.0	86.2	13.8	0.0	79.3	19.8	0.9	75.0	23.3	1.7	89.7	10.3	0.0	83.6	16.4	0.0	1.15	92.4			
СЭМҮТ	70	88.6	10.0	1.4	88.6	10.0	1.4	90.0	10.0	0.0	92.9	7.1	0.0	94.3	5.7	0.0	94.3	5.7	0.0	85.7	12.9	1.4	97.1	2.9	0.0	92.9	7.1	0.0	1.08	95.8						
ГҮТ	30	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	93.3	6.7	0.0	83.3	16.7	0.0	100.0	0.0	0.0	96.7	3.3	0.0	1.03	98.7			
Дундаж		балл			1.27			1.25			1.22			1.16			1.14			1.17			1.26			1.33			1.11			1.18			1.21	
		хувь			86.5			87.6			88.8			92.2			93.1			91.4			87.1			83.4			94.3			91.0			89.5	


**Бүлгийн дүгнэлт**

Бүлгийн дүгнэлтийг илүү бодитой болгохын тулд байгууллагын сэтгэлд нийцсэн үйлчилгээ, соёлын талаар 2013 оноос ахиц, дэвшил гарсан эсэхийг 2014 онтой харьцуулан, дүгнэлээ.

**Байгууллагын соёлын сэтгэл ханамжийн түвшин, 2013-2014 он**



**Байгууллагын соёлын сэтгэл ханамжийн түвшин, 2013-2014 он**



Байгууллагын сэтгэлд нийцсэн үйлчилгээ, соёлын талаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 2013 онд 79.2% байсан бол 2014 онд 89.5% болж 10.3% дээшилсэн амжилттай байна. ХӨСҮТ, ГССҮТ, АӨСҮТ-ийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн хувь бусад байгууллагуудаас илүү өндөр хувиар нэмэгдсэн байна.

Эмч, ажилтны байгууллагын сэтгэлд нийцсэн, үйлчилгээ, соёлын талаарх сэтгэл ханамжийн түвшин 2013 онд 82.1% байсан бол 2014 онд 90.5% болж 8.4% дээшилсэн байна. Гэхдээ УХТЭ, УНТЭ, ЗӨСҮТ, НЭМҮТ-ийн сэтгэл ханамжийн түвшин цөөн хувиар буурсан байна.

Бүлгийн үзүүлэлтээр авч үзвэл, 2014 онд байгууллагын сэтгэлд нийцсэн үйлчилгээнээс эмч, мэргэжилтний хувцаслалтын соёлд сэтгэл ханамжийн түвшин хамгийн өндөр (94.3%), байгууллагын гадаад орчны тав тухад хамгийн бага (83.4%) байна.

### БҮЛЭГ 3. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХАРИЛЦАА, ЁС ЗҮЙ


Эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа ёс зүйг хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд 5 хэмжигдэхүүн, эмч, ажилчдын сэтгэл ханамжийн судалгаанд 7 хэмжигдэхүүнээр тус тус тодорхойлсон.

Эмч, ажилчдын сэтгэл ханамжийн судалгаанд байгууллагын захирлын болон, тасаг нэгжийн удирдлагын харилцаа, ёс зүйн талаар асуулга 2014 оны тушаалаар шинээр нэмэгдэж орсон болно.

Эмнэлгийн мэргэжилтний харилцаа, ёс зүйн талаар хэмжигдэхүүн болон байгууллага бүрээр харьцуулан авч үзэхдээ сэтгэл ханамж өндөр буюу “сайн” гэсэн үнэлгээг авлаа. Мөн хэрэглэгчийн өгсөн үнэлгээг, эмч ажилтны өөрсдийгөө үнэлсэн байдалтай харьцуулан тодорхойлов.

“Эмчийн харилцаа, ёс зүйд”-нд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 91.7%-тай, эмч, ажилтны сэтгэл ханамжийн түвшин 88.5%-тай, 3.2%-ийн зөрөөтэй, хэрэглэгчид илүү сэтгэл ханамжтай байна.

Зураг 13. Эмчийн харилцаа, ёс зүй




Эмчийн харилцаа, ёс зүйд хэрэглэгчид 73.5-100.0%-ийн сэтгэл ханамжтай, эмч, ажилтан 68.0-100.0%-ийн сэтгэл ханамжтай байна. Үнэлгээнээс харахад ЭХЭМҮТ-ийн сэтгэл ханамж ойролцоо түвшинд, УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ХӨСҮТ, ГССҮТ, СЭМҮТ-ийн хэрэглэгчид эмч, ажилтнаас илүү хувиар сэтгэл ханамж өндөр байгаа нь сайн үзүүлэлт юм.

Ялангуяа ГССҮТ, УХТЭ-ийн эмч, ажилчдын үнэлгээ 68.0-70.3%тай байхад үйлчлүүлэгчид нь 80.0%-аас дээш сэтгэл ханамжтай “сайн” гэж үнэлсэн байна.

“Сувилагчийн харилцаа, ёс зүй”-д хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 93.3%-тай, үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.7%-тай, хэрэглэгчид илүү сэтгэл ханамжтай байна.


Зураг 14. Сувилагчийн харилцаа, ёс зүй



Сувилагчийн харилцаа, ёс зүйд хэрэглэгчид 85.1-100.0%-ийн сэтгэл ханамжтай, эмч, ажилтан 71.1-100.0%-ийн сэтгэл ханамжтай байна. Үнэлгээнээс харахад АӨСҮТ, ХСҮТ-өөс бусад байгууллагуудад хэрэглэгчид өөрсдийнх нь үнэлгээнээс дээгүүр үнэлгээ өгсөн нь сувилагчдын харилцаа, ёс зүйд сэтгэл ханамж “сайн” байгааг харуулж байна.

“Асаргаа, үйлчилгээний ажилтны харилцаа, ёс зүйд”-д хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 93.0%-тай, үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 88.9%-тай, хэрэглэгчид илүү сэтгэл ханамжтай байна.


**Зураг 15. Асаргаа, үйлчилгээний ажилтны харилцаа, ёс зүй**



Асаргаа, үйлчилгээний ажилтны харилцаа, ёс зүйд хэрэглэгчид 80.8-100.0%-ийн сэтгэл ханамжтай, эмч, ажилтан 68.0-100.0%-ийн сэтгэл ханамжтай байна. Мөн АӨСҮТ-өөс бусад байгууллагуудад хэрэглэгчид өөрсдийнх нь үнэлгээнээс дээгүүр үнэлгээ өгсөн нь сэтгэл ханамж “сайн” байгааг харуулж байна.

“Үйлчлүүлэгчийн нууц хадгалалт, итгэх итгэл”-д хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 91.3%-тай, үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 93.0%-тай, байна.

**Зураг 16. Үйлчлүүлэгчийн нууц хадгалалт, итгэх итгэл**




Үйлчлүүлэгчийн нууц хадгалалт, итгэх итгэлийн талаар хэрэглэгчид 75.8-100.0%-ийн сэтгэл ханамжтай, эмч, ажилтан 78.4-100.0%-ийн сэтгэл ханамжтай байна. Ерөнхийдөө хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжтай байдлын түвшин их ойролцоо байгаа ба ГССҮТ-ийн эмч ажилтан, хэрэглэгчийн сэтгэл ханамж хамгийн бага байна.

Энэ бүлэгт бид зөвхөн эмч, ажилтнаас эмнэлгийн удирдлагын харилцаа, ёс зүй, хамт олны харилцаа, бие биенээ хүндлэх байдал, эв нэгдлийн талаар тусгайлан асуусан.

Эмнэлгийн захирлын харилцаа, ёс зүй сэтгэл ханамжийн түвшин 92.3%-тай, тасаг нэгжийн удирдлагын харилцаа, ёс зүй сэтгэл ханамжийн түвшин 90.7%-тай байна.


**Зураг 17. Эмнэлгийн захирал, тасаг нэгжийн удирдлагын харилцаа, ёс зүй**



Эмнэлгийн захирлын харилцаа, ёс зүйн талаар эмч ажилтны сэтгэл ханамжид “сайн” гэж үнэлгээ өгсөн хувь 55.0-100.0%, тасаг нэгжийн удирдлагын харилцаа, ёс зүй 69.1-100.0%-тай байна. ЗӨСҮТ-ийн сэтгэл ханамжтай байдал хамгийн бага 55.0-70.0%-тай байна.

Эмч, эмнэлгийн мэргэжилтний бие, биенээ хүндэтгэх ёс зүйн сэтгэл ханамжийн түвшин 88.5%, хамт олны харилцаа, эв нэгдлийн сэтгэл ханамжийн түвшин 91.2%-тай байна.

Зураг 18. Эмнэлгийн мэргэжилтний бие, биенээ хүндэтгэх ёс зүй болон хамт олны харилцаа, эв нэгдэл



Эмч, эмнэлгийн мэргэжилтний бие, биенээ хүндэтгэх ёс зүйн сэтгэл ханамжийн хувь 40.0-100.0%-тай, хамт олны харилцаа, эв нэгдэлд өгсөн сэтгэл ханамжийн хувь 30.0-100.0%-тай байна. ЗӨСҮТ-ийн сэтгэл ханамжтай байдал хамгийн бага 30.0-40.0%-тай байна.

**ХҮСНЭГТ 4. ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХАРИЛЦАА, ЁС ЗҮЙ**

Хүснэгт 4.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны сэтгэл ханамж


Эмнэлгийн нэр	n	Эмнэлгийн захирлын харилцаа, ёс зүй			Тасаг нэгжийн даргын харилцаа, ёс зүй			Эмчийн харилцаа, ёс зүй			Сувилагчийн харилцаа, ёс зүй			Асаргаа, үйлчилгээний ажилтны харилцаа, ёс зүй			Эмч, эмнэлгийн мэргэжилтний бие биенээ хүндэтгэх ёс зүй			Хамт олны харилцаа, эв нэгдэл			Үйлчлүүлэгчийн нууц хадгалалт, итгэх итгэл			Бүлгийн дундаж		
		Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	балл	хувь	
ЭХЭМҮТ	183	93.4	6.6	0.0	80.9	17.5	1.6	74.3	24.0	1.6	79.8	20.2	0.0	76.5	22.4	1.1	73.8	25.7	0.5	84.7	14.2	1.1	86.3	13.7	0.0	1.19	90.5	
УНТЭ	138	84.1	15.9	0.0	83.3	15.9	0.7	81.2	17.4	1.4	83.3	15.2	1.4	76.8	21.0	2.2	81.9	18.1	0.0	89.9	10.1	0.0	87.7	12.3	0.0	1.17	91.6	
УХТЭ	74	90.5	9.5	0.0	70.3	29.7	0.0	70.3	27.0	2.7	81.1	18.9	0.0	77.0	20.3	2.7	67.6	31.1	1.4	79.7	17.6	2.7	83.8	14.9	1.4	1.23	88.4	
УГТЭ	127	78.7	18.9	2.4	80.3	18.9	0.8	76.4	23.6	0.0	81.1	18.1	0.8	78.7	20.5	0.8	82.7	15.7	1.6	83.5	16.5	0.0	81.9	15.0	3.1	1.20	89.9	
ХСҮТ	82	100.0	0.0	0.0	91.5	8.5	0.0	89.0	11.0	0.0	91.5	8.5	0.0	90.2	8.5	1.2	90.2	9.8	0.0	98.8	1.2	0.0	97.6	2.4	0.0	1.06	96.9	
ХӨСҮТ	144	84.7	13.9	1.4	85.4	13.9	0.7	82.6	14.6	2.8	79.2	20.1	0.7	78.5	20.1	1.4	73.6	25.0	1.4	79.2	20.8	0.0	86.1	13.2	0.7	1.21	89.6	
ГССҮТ	97	73.2	26.8	0.0	69.1	29.9	1.0	68.0	32.0	0.0	71.1	28.9	0.0	68.0	29.9	2.1	72.2	25.8	2.1	77.3	21.6	1.0	78.4	20.6	1.0	1.28	86.0	
АӨСҮТ	26	92.3	7.7	0.0	96.2	3.8	0.0	92.3	3.8	3.8	96.2	3.8	0.0	100.0	0.0	0.0	96.2	3.8	0.0	96.2	3.8	0.0	96.2	3.8	0.0	1.05	97.6	
СЭМҮТ	89	92.1	7.9	0.0	91.0	9.0	0.0	83.1	16.9	0.0	85.4	14.6	0.0	79.8	18.0	2.2	79.8	20.2	0.0	84.3	15.7	0.0	92.1	7.9	0.0	1.14	92.8	
ЗӨСҮТ	20	55.0	35.0	10.0	70.0	15.0	15.0	55.0	40.0	5.0	70.0	30.0	0.0	70.0	30.0	0.0	40.0	55.0	5.0	30.0	60.0	10.0	50.0	50.0	0.0	1.52	74.2	
ГҮТ	18	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	1.00	100.0	
ХТС	33	93.9	3.0	3.0	90.9	6.1	3.0	75.8	21.2	3.0	90.9	6.1	3.0	81.8	18.2	0.0	87.9	9.1	3.0	90.9	6.1	3.0	97.0	0.0	3.0	1.13	93.4	
ЦССҮТ	45	64.4	33.3	2.2	86.7	13.3	0.0	75.6	22.2	2.2	77.8	22.2	0.0	86.7	13.3	0.0	75.6	24.4	0.0	68.9	28.9	2.2	86.7	11.1	2.2	1.23	88.3	
ЭСҮТ	37	75.7	21.6	2.7	81.1	10.8	8.1	83.8	13.5	2.7	81.1	18.9	0.0	83.8	16.2	0.0	81.1	16.2	2.7	78.4	16.2	5.4	94.6	5.4	0.0	1.21	89.6	
НЭМҮТ																												
Дундаж	балл	1.15			1.19			1.23			1.19			1.22			1.23			1.18			1.14			1.19		
Дундаж	хувь	92.3			90.7			88.5			90.7			88.9			88.5			91.2			93.0			90.6		

Хүснэгт 4.2. Хэрэглэгчийн сэтгэл ханамж


Эмнэлгийн нэр	n	Эмнэлгийн удирдах ажилтны найрсаг харилцаа, ёс зүй			Эмчийн найрсаг харилцаа, ёс зүй			Сувилагчийн найрсаг харилцаа, ёс зүй			Асаргаа, үйлчилгээний ажилтны найрсаг харилцаа, ёс зүй			Үйлчлүүлэгчийн нууц хадгалалт, итгэх итгэл			Бүлгийн дундаж	
		Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	балл	хувь
ЭХЭМҮТ	219	73.5	24.7	1.8	84.5	12.8	2.7	80.8	15.5	3.7	75.8	17.8	6.4	81.7	16.9	1.4	1.24	88.0
УНТЭ	228	83.8	15.8	0.4	85.1	14.5	0.4	87.3	11.4	1.3	86.8	11.8	1.3	89.5	10.1	0.4	1.14	92.9
УХТЭ	118	85.6	11.9	2.5	88.1	10.2	1.7	90.7	6.8	2.5	85.6	13.6	0.8	88.1	11.9	0.0	1.14	93.1
УГТЭ	187	86.1	12.3	1.6	89.3	9.6	1.1	88.2	10.7	1.1	86.6	12.3	1.1	88.2	11.8	0.0	1.13	93.4
ХСҮТ	126	90.5	7.9	1.6	85.7	11.9	2.4	90.5	8.7	0.8	87.3	11.1	1.6	92.1	7.1	0.8	1.12	93.9
ХӨСҮТ	194	89.2	10.8	0.0	94.3	5.2	0.5	93.3	6.2	0.5	90.2	8.2	1.5	89.7	8.2	2.1	1.10	95.2
ГССҮТ	204	80.4	18.1	1.5	82.8	16.7	0.5	80.9	17.6	1.5	76.0	21.6	2.5	81.9	17.2	1.0	1.21	89.5
АӨСҮТ	116	87.1	12.9	0.0	89.7	10.3	0.0	86.2	12.9	0.9	88.8	10.3	0.9	88.8	10.3	0.9	1.12	93.8
СЭМҮТ	70	92.9	5.7	1.4	91.4	7.1	1.4	95.7	4.3	0.0	90.0	10.0	0.0	98.6	1.4	0.0	1.07	96.6
ГҮТ	30	96.7	3.3	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	96.7	3.3	0.0	1.01	99.3
Дундаж	балл	1.17			1.13			1.14			1.17			1.13			1.15	
Дундаж	хувь	91.7			93.3			93.0			91.3			93.5			92.5	

Бүлгийн дүгнэлт

Эмнэлгийн мэргэжилтний харилцаа, ёс зүйн сэтгэл ханамжийн түвшин, 2013-2014 он



Эмнэлгийн мэргэжилтний харилцаа, ёс зүйн сэтгэл ханамжийн түвшин, 2013-2014 он



Эмнэлгийн мэргэжилтний харилцаа, ёс зүйн талаар *хэрэглэгчийн* сэтгэл ханамжийн түвшин 2013 онд 90.6% байсан бол 2014 онд 92.5% болж 1.9% дээшилсэн амжилттай байна. УГТЭ, ХӨСҮТ, ГССҮТ, СЭМҮТ, АӨСҮТ-ийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн хувь нэмэгдсэн байна.

Эмнэлгийн мэргэжилтний харилцаа, ёс зүйн талаар *эмч, ажилтны* сэтгэл ханамжийн түвшин 2013 онд 86.9% байсан бол 2014 онд 83.9% болж 3% буурсан байна. УХТЭ, ГССҮТ, ЗӨСҮТ, ЭСҮТ-ийн сэтгэл ханамжийн түвшин буурсан байна.

Бүлгийн үзүүлэлтээр авч үзвэл, 2014 онд эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа ёс зүйгээс “Үйлчлүүлэгчийн нууц хадгалалт итгэх итгэл”д сэтгэл ханамжийн түвшин хамгийн өндөр (93.5%), асаргаа, үйлчилгээний ажилтны харилцаа, ёс зүйд сэтгэл ханамжийн түвшин 91.0% байгаа нь бүлэг дотроо бага хувь болж байна.


#### БҮЛЭГ 4. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ УР ЧАДВАР, ХАРИУЦЛАГА

Эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадвар, хариуцлагын талаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд 7 хэмжигдэхүүнээр, эмч, ажилчдын сэтгэл ханамжийн судалгаанд 10 хэмжигдэхүүнээр тус тус тодорхойлсон. Мөн эмч, эмнэлгийн мэргэжилтний судалгаанд байгууллагын захирал, тасаг нэгжийн удирдлагын ур чадвар, хариуцлагын талаар тусгайлан асуусан болно.

Эмнэлгийн мэргэжилтний ур чадвар, хариуцлагын талаар хэмжигдэхүүн болон байгууллага бүрээр харьцуулан авч үзэхдээ сэтгэл ханамж өндөр буюу “сайн” гэсэн үнэлгээг авлаа.

“Эмчийн сонсох, зөвлөгөө өгөх ур чадвар”-т хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 93.4%-тай, эмч, ажилтны сэтгэл ханамжийн түвшин 93.6%-тай ижил түвшинд байна.


Зураг 19. Эмчийн зөвлөгөө өгөх ур чадвар



Эмчийн зөвлөгөө өгөх ур чадварт хэрэглэгчид 83.8-100.0%-ийн сэтгэл ханамжтай, эмч, ажилтан 79.7-100.0%-ийн сэтгэл ханамжтай байна. Эмчийн зөвлөгөө өгөх ур чадварын сэтгэл ханамжийн хувь аль, аль талдаа их ойролцоо түвшинд байгаа ба УХТЭ өөрсдийнхөө ур чадварт 79.7%-иар сэтгэл ханамж сайн гэсэн хамгийн бага хувийг эзэлж байна.

“Эмчийн эмчлэх ур чадвар”-т хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 95.1%-тай, эмч, ажилтны сэтгэл ханамжийн түвшин 95.0%-тай ижил түвшинд байна.


Зураг 20. Эмчийн эмчлэх ур чадвар



Эмчийн эмчлэх ур чадварт хэрэглэгчид 86.4-100.0%-ийн сэтгэл ханамжтай, эмч, ажилтан 81.1 -100.0%-ийн сэтгэл ханамжтай байна. Үнэлгээнээс харахад ЭХЭМҮТ, АӨСҮТ, УГТЭ ижил түвшинд байна.

“Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний сонсох, зөвлөх ур чадвар”-т хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 92.8%-тай, эмч, ажилтны сэтгэл ханамжийн түвшин 93.1%-тай ойролцоо түвшинд байна.


**Зураг 21. Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний сонсох, зөвлөх ур чадвар**



Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний сонсох, зөвлөх ур чадварт хэрэглэгчийн 77.9%-100.0% сайн гэсэн үнэлгээ өгсөн бол эмч, ажилтан 84.5-100.0 “сайн” гэсэн ба үнэлгээ маш ойролцоо түвшинд, өндөр хувьтай байна.

“Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын хариуцлага”-д хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 92.3%-тай, эмч, ажилтны сэтгэл ханамжийн түвшин 92.3%-тай ижил түвшинд байна.


**Зураг 22. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын хариуцлага**



Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын хариуцлагын талаар хэрэглэгчид 77.2-100.0 сэтгэл ханамж “сайн” гэсэн хариулт өгсөн байна. УНТЭ, УГТЭ, УХТЭ, ХӨСҮТ, СЭМҮТ-ийн хэрэглэгчийн үнэлгээ, өөрсдийнх нь өгсөн үнэлгээнээс дээгүүр байна.

“Эмч, эмнэлгийн мэргэжилтний шуурхай байдал”-д хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 91.2%-тай, эмч, ажилтны сэтгэл ханамжийн түвшин 92.3%-тай ойролцоо түвшинд байна.

**Зураг 23. эмч, эмнэлгийн мэргэжилтний шуурхай байдал**






Шуурхай байдалд хэрэглэгчийн 74.4%-100.0% “сайн” гэж үнэлгээ өгсөн бол эмч, ажилтан өөрсдийгөө 73.0-100.0 “сайн” гэж үнэлжээ. Эмч, мэргэжилтний хувьд шуурхай байдалдаа УХТЭ хамгийн бага хувиар, ГҮТ хамгийн өндөр хувиар сэтгэл ханамжтай байна.

Бид мөн энэ бүлэгтээ “эмнэлгийн захирал, тасаг нэгжийн удирдлагын ажлын хариуцлага”-ын талаар эмч, ажилтнаас тусгайлан судалсан болно.

Зураг 24. Эмнэлгийн захирал, тасаг нэгжийн удирдлагын ажлын хариуцлага



Эмнэлгийн захирлын ажлын хариуцлагын сэтгэл ханамжийн түвшин 92.9%-тай, тасаг нэгжийн удирдлагын ажлын хариуцлагын сэтгэл ханамжийн түвшин 91.6%-тай байна. Удирдлагадаа хамгийн сэтгэл ханамж багатай байгууллага ЗӨСҮТ байна.

ХҮСНЭГТ 5. ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ УР ЧАДВАР, ХАРИУЦЛАГА

Хүснэгт 5.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны сэтгэл ханамж

Эмнэлгийн нэр	n	Эмнэлгийн захирлын ажлын хариуцлага			Тасаг нэгжийн удирдлагын ажлын хариуцлага			Тасаг нэгжийн удирдлагын ажлын хариуцлага			Эмч, эмнэлгийн мэргэжилтний шуурхай байдал			Эмч, эмнэлгийн мэргэжилтний шуурхай байдал			Эмчийн сонсох, зөвлөгөө өгөх үр чадвар			Эмч, мэргэжилтний оношлох үр чадвар			Эмчийн эмчлэх үр чадвар			Сүвिलाгч, эмнэлгийн мэргэжилтний сонсох, зөвлөгөө өгөх үр чадвар			Бүлгийн дундаж		
		Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	балл	хувь	
ЭХЭМҮТ	183	97.8	2.2	0.0	84.7	13.7	1.6	82.0	15.8	2.2	85.2	14.8	0.0	87.4	12.6	0.0	85.2	14.2	0.5	90.7	8.7	0.5	91.3	8.7	0.0	86.9	12.6	0.5	1.12	93.8	
УНТЭ	138	86.2	13.8	0.0	87.7	12.3	0.0	87.0	13.0	0.0	87.7	12.3	0.0	89.9	9.4	0.7	91.3	8.0	0.7	93.5	6.5	0.0	93.5	6.5	0.0	92.0	8.0	0.0	1.10	95.0	
УХТЭ	74	81.1	17.6	1.4	70.3	27.0	2.7	71.6	27.0	1.4	77.0	23.0	0.0	73.0	27.0	0.0	79.7	20.3	0.0	78.4	21.6	0.0	81.1	18.9	0.0	85.1	14.9	0.0	1.21	89.6	
УГТЭ	127	87.4	10.2	2.4	77.2	21.3	1.6	81.9	18.1	0.0	85.8	13.4	0.8	77.2	22.0	0.8	86.6	13.4	0.0	86.6	13.4	0.0	89.8	10.2	0.0	83.5	16.5	0.0	1.16	91.9	
ХСҮТ	82	98.8	1.2	0.0	92.7	7.3	0.0	91.5	8.5	0.0	95.1	4.9	0.0	97.6	2.4	0.0	93.9	6.1	0.0	96.3	3.7	0.0	97.6	2.4	0.0	92.7	7.3	0.0	1.05	97.5	
ХӨСҮТ	144	79.9	20.1	0.0	86.1	13.2	0.7	84.0	14.6	1.4	86.1	13.9	0.0	84.0	16.0	0.0	87.5	12.5	0.0	87.5	12.5	0.0	91.0	9.0	0.0	83.3	16.7	0.0	1.15	92.5	
ГССҮТ	97	70.1	27.8	2.1	81.4	18.6	0.0	80.4	17.5	2.1	81.4	17.5	1.0	82.5	16.5	1.0	86.6	13.4	0.0	85.6	14.4	0.0	86.6	13.4	0.0	84.5	14.4	1.0	1.19	90.3	
АӨСҮТ	26	92.3	7.7	0.0	92.3	7.7	0.0	92.3	7.7	0.0	92.3	7.7	0.0	92.3	7.7	0.0	96.2	3.8	0.0	92.3	7.7	0.0	96.2	3.8	0.0	88.5	11.5	0.0	1.07	96.7	
СЭМҮТ	89	97.8	2.2	0.0	95.5	4.5	0.0	89.9	10.1	0.0	86.5	13.5	0.0	85.4	14.6	0.0	92.1	7.9	0.0	88.8	11.2	0.0	94.4	5.6	0.0	86.5	13.5	0.0	1.09	95.4	
ЗӨСҮТ	20	50.0	45.0	5.0	50.0	35.0	15.0	50.0	30.0	20.0	45.0	50.0	5.0	50.0	45.0	5.0	60.0	40.0	0.0	85.0	10.0	5.0	70.0	30.0	0.0	65.0	35.0	0.0	1.49	75.8	
ГҮТ	18	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	94.4	5.6	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	1.01	99.7	
ХТС	33	93.9	3.0	3.0	90.9	6.1	3.0	81.8	15.2	3.0	87.9	9.1	3.0	90.9	6.1	3.0	90.9	6.1	3.0	81.8	18.2	0.0	84.8	15.2	0.0	97.0	0.0	3.0	1.13	93.4	
ЦССҮТ	45	80.0	17.8	2.2	88.9	11.1	0.0	71.1	28.9	0.0	77.8	22.2	0.0	86.7	13.3	0.0	88.9	11.1	0.0	86.7	13.3	0.0	82.2	15.6	2.2	86.7	13.3	0.0	1.16	92.1	
ЭСҮТ	37	70.3	24.3	5.4	75.7	18.9	5.4	75.7	18.9	5.4	81.1	18.9	0.0	86.5	13.5	0.0	78.4	21.6	0.0	86.5	10.8	2.7	83.8	16.2	0.0	78.4	18.9	2.7	1.23	88.5	
НЭМТ																															
Дундаж		балл	1.14		1.17		1.19		1.15		1.15		1.13		1.12		1.12		1.10		1.12		1.10		1.14		1.14		1.14		1.14
		хувь	92.9		91.6		90.6		92.3		92.3		93.6		94.2		93.6		94.2		94.2		95.0		93.1		93.1		93.0		93.0


Хүснэгт 5.2. хэрэглэгчийн сэтгэл ханамж

Эмнэлгийн нэр	n	Эмчийн сонсох, зөвлөгөө өгөх үр чадвар			Эмчийн оношлох үр чадвар			Эмчийн эмчлэх үр чадвар			Сүвिलाгч, эмнэлгийн мэргэжилтний сонсох, зөвлөгөө өгөх үр чадвар			Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын хариуцлага			Эмч, эмнэлгийн мэргэжилтний шуурхай байдал			Бүлгийн дундаж		
		Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	балл	хувь	
ЭХЭМҮТ	219	85.4	12.8	1.8	90.9	9.1	0.0	88.1	11.4	0.5	79.0	19.6	1.4	77.2	21.5	1.4	74.4	23.3	2.3	1.19	90.6	
УНТЭ	228	83.8	15.4	0.9	89.0	10.5	0.4	91.7	7.9	0.4	89.5	10.1	0.4	89.0	10.1	0.9	86.8	11.8	1.3	1.12	93.8	
УХТЭ	118	84.7	13.6	1.7	86.4	10.2	3.4	86.4	11.0	2.5	86.4	13.6	0.0	80.5	16.9	2.5	82.2	16.1	1.7	1.18	91.2	
УГТЭ	187	89.8	9.6	0.5	88.2	10.7	1.1	88.8	10.2	1.1	88.2	11.2	0.5	88.8	10.2	1.1	84.0	15.0	1.1	1.13	93.5	
ХСҮТ	126	88.9	8.7	2.4	92.1	6.3	1.6	92.1	5.6	2.4	84.9	11.9	3.2	84.1	12.7	3.2	84.9	11.1	4.0	1.15	92.5	
ХӨСҮТ	194	90.7	9.3	0.0	94.8	4.6	0.5	94.8	5.2	0.0	92.3	7.2	0.5	88.7	10.8	0.5	87.6	12.4	0.0	1.09	95.6	
ГССҮТ	204	88.2	10.3	1.5	90.7	8.8	0.5	90.2	9.3	0.5	77.9	21.1	1.0	81.4	17.6	1.0	80.4	17.6	2.0	1.16	91.9	
АӨСҮТ	116	88.8	10.3	0.9	92.2	7.8	0.0	91.4	8.6	0.0	87.9	12.1	0.0	88.8	11.2	0.0	84.5	15.5	0.0	1.11	94.4	
СЭМҮТ	70	92.9	7.1	0.0	95.7	4.3	0.0	94.3	5.7	0.0	97.1	2.9	0.0	97.1	2.9	0.0	94.3	5.7	0.0	1.05	97.6	
ГҮТ	30	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	1.00	100.0	
Дундаж		балл	1.13		1.10		1.10		1.10		1.14		1.15		1.15		1.18		1.13		1.13	
		хувь	93.4		95.1		95.1		95.1		92.8		92.3		92.3		91.2		93.3		93.3	

**Бүлгийн дүгнэлт**

Энэхүү бүлэг нь 2014 онд шинээр нэмэлтээр хариуцлагын үзүүлэлтүүд орж ирсэн учир 2013 онтой харьцуулалт хийгээгүй. 2014 оны үзүүлэлтээр бүлгийн дүгнэлт хийлээ.

**Эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадвар, хариуцлагын сэтгэл ханамжийн түвшин, 2014 он**



ХЭРЭГЛЭГЧИЙН эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадвар, хариуцлагын талаарх сэтгэл ханамжийн түвшин 93.0%-тай байна. ГҮТ, СЭМҮТ-ийн хэрэглэгчид (97.6%) хамгийн сэтгэл ханамж өндөртэй байна.

Эмч, эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн түвшин 93.0%-тай байна. Өөрсдийнхөө ур чадвар, хариуцлагад ГҮТ-ийн эмч, ажилтан (99.7%) хамгийн сэтгэл ханамжтай байна.

Бүлгийн үзүүлэлтээр авч үзвэл “эмчийн эмчлэх ур чадвар”-т (95.0%) хамгийн өндөр сэтгэл ханамжтай байгаа ба 90.0%-аас доош үзүүлэлт байхгүй байна.

Тусгай мэргэжлийн төвүүдээс өөрийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадвар, ажлын хариуцлагад ЗӨСҮТ-ийн эмч мэргэжилтэн сэтгэл дундуур, сэтгэл ханамжийн түвшин 75.8%тай байна. Энэ нь хэдийгээр “сайн” гэсэн үзүүлэлтэд хамаарах боловч бусад байгууллагаас харьцангуй бага хувь болж байна.


### БҮЛЭГ 5. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний аюулгүй байдлын талаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийг 8 хэмжигдэхүүнээр, эмч, ажилчдын сэтгэл ханамжийг 6 хэмжигдэхүүнээр тодорхойлсон. Эмч, ажилчдаас тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж ажиллах боломжийн талаар 6 хэмжигдэхүүнээр нэмж, тодотгон асуусан болно.

Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг мэргэжилтний ур чадвар, хариуцлагын талаар хэмжигдэхүүн болон байгууллага бүрээр харьцуулан авч үзэхдээ сэтгэл ханамж өндөр буюу “сайн” гэсэн үнэлгээг авлаа.

“Оношилгооны чанар, аюулгүй байдал”-д хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 92.8%-тай, эмч, ажилтны сэтгэл ханамжийн түвшин 92.1%-тай ижил түвшинд байна.


Зураг 25. Оношилгооны чанар, аюулгүй байдал



Оношилгооны чанар, аюулгүй байдалд хэрэглэгчид 78.9-100.0%, эмч ажилчид 71.6-100.0% сэтгэл ханамжтай, “сайн” гэсэн үнэлгээ өгсөн байна. Зургаас харахад ХӨСҮТ, СЭМҮТ-ийн хэрэглэгчид илүү сэтгэл ханамж өндөр байна. УХТЭ-ийн өөрсдийн сэтгэл ханамж хэрэглэгчдээс 14.8%-иар бага байна.

“Эмчилгээний чанар, аюулгүй байдал”-д хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 92.8%-тай, эмч, ажилтны сэтгэл ханамжийн түвшин 92.1%-тай ижил түвшинд байна.


Зураг 26. Эмчилгээний чанар, аюулгүй байдал



Эмчилгээний чанар, аюулгүй байдалд хэрэглэгчид 84.9-100.0%, эмч ажилчид 73.2-100.0% сэтгэл ханамжтай, “сайн” гэсэн үнэлгээ өгсөн байна. ГССҮТ-ийн эмч, ажилтан, хэрэглэгчдээсээ 14.1%-иар сэтгэл ханамж бага байна.

“Эм олгох, түгээх, тариа хийх үйлдлийн аюулгүй байдал”-д хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 92.7%-тай, эмч, ажилтны сэтгэл ханамжийн түвшин 92.1%-тай ижил түвшинд байна.


**Зураг 27. Эм олгох, түгээх, тариа хийх үйлдлийн аюулгүй байдал**



Эм олгох, түгээх, тариа хийх үйлдлийн аюулгүй байдал хэрэглэгчийн 84.5-100.0% нь “сайн” гэж үнэлсэн бол эмч, ажилтан 70.1-100.0% ”сайн” гэж үнэлсэн байна. Байгууллагаар харахад ГССҮТ-ийн эмч, ажилчдын сэтгэл ханамж хамгийн бага хувьтай, хэрэглэгчдээсээ 12.6%-ийн зөрөөтэй байна.

“Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал”-д хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 90.5%-тай, эмч, ажилтны сэтгэл ханамжийн түвшин 87.2%-тай, хэрэглэгч 3.3%-иар илүү сэтгэл ханамжтай байна.


**Зураг 28. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал**



Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд хэрэглэгчид 74.0-100.0%-ийн “сайн” гэсэн үнэлгээ өгсөн бол эмч, ажилтан 56.8-100.0% сэтгэл ханамжтай байна. УХТЭ-ийн эмч, ажилтан өөрийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал хамгийн сэтгэл ханамж багатай, хэрэглэгчдээсээ 29.6%иар бага байна. Мөн ХӨСҮТ-ийн эмч, ажилчид хэрэглэгчийн сэтгэл ханамжийн зөрөө 13.7%тай байна.

“Эмнэлгийн барилга, байгууламжийн аюулгүй байдал”-д хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 88.3%-тай, эмч, ажилтны сэтгэл ханамжийн түвшин 82.7%-тай, 5.6%-иар хэрэглэгчид илүү сэтгэл ханамжтай байна.


**Зураг 29. Эмнэлгийн барилга, байгууламжийн аюулгүй байдал**



Эмнэлгийн барилга байгууламжийн аюулгүй байдалд хэрэглэгчид 73.5-97.1%-иар, эмч, ажилтан 50.0-85.4%-ийн сэтгэл ханамжтай байна. Ялангуяа УХТЭ, УГТЭ, ГССҮТ, СЭМҮТ-ийн эмч, ажилтны сэтгэл ханамж бага, цөөнгүй хувиар дунд, муу гэсэн үнэлгээ өгсөн дүр зураг харагдаж байна.

“Эмнэлгийн халдвар хамгаалал, эрүүл ахуйн аюулгүй байдал”-д хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин 90.1%-тай, эмч, ажилтны сэтгэл ханамжийн түвшин 87.2%-тай, 2.9%-иар хэрэглэгчид илүү сэтгэл ханамжтай байна.

**Зураг 30. Эмнэлгийн халдвар хамгаалал, эрүүл ахуйн аюулгүй байдал**



Эмнэлгийн халдвар хамгаалал, эрүүл ахуйн аюулгүй байдалд хэрэглэгчид 74.0-100.0%, эмч ажилчид 57.7-100.0% “сайн” гэсэн үнэлгээ өгсөн байна. ХӨСҮТ-ийн эмч ажилтан хэрэглэгчээсээ 21.4%-иар, ГССҮТ-ийн эмч ажилтан 17.3%-иар зөрөөгөөр сэтгэл ханамж багатай байна.

Бид судалгаандаа эмч, ажилтнаас тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах боломж нь хэр байдаг талаар 6 үзүүлэлтээр үнэлгээ өгүүлэв.

“Тусламж, үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах боломж”-ийн талаар сэтгэл ханамжийн түвшин 91.8%-тай байна. Байгууллагаар авч үзвэл ЭХЭМҮТ, УНТЭ, УГТЭ, ХСҮТ, АӨСҮТ, СЭМҮТ, ГҮТ, ХТС, ЦССҮТ нь 85.5-100.0%-иар “сайн” гэж үнэлсэн бол ЭСҮТ стандарт мөрдөх боломж хамгийн бага буюу 43.2% нь “дунд”, 5.4% нь “муу” гэсэн үнэлгээ өгчээ.

“Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах боломж”-ийн талаар сэтгэл ханамжийн түвшин 91.0%-тай байна. Хамгийн өндөр хувиар ГҮТ, ХТС, ХСҮТ “сайн” гэсэн үнэлгээг өгчээ.


“Асаргаа, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах боломж”-ийн талаар сэтгэл ханамжийн түвшин 88.9%-тай байна. ГҮТ, ХСҮТ, АӨСҮТ, ХТС нь 90.9-100.0%-иар сэтгэл ханамж өндөр байна. Ортой эмнэлгүүдээс ГССҮТ-ийн эмч, ажилтны 32.0% нь сэтгэл ханамжгүй байгаа нь хамгийн өндөр хувь болж байна.

“Яаралтай тусламжийн чанар, аюулгүй байдлыг хангах ажиллах боломж”-ийн талаар сэтгэл ханамжийн түвшин 89.9%-тай байна. ЭХЭМҮТ, УНТЭ, УГТЭ, ХСҮТ, АӨСҮТ, ГҮТ, ХТС, ЦССҮТ нь 85.2-100.0% “сайн” гэсэн үнэлгээ өгчээ. Харин ГССҮТ, ЗӨСҮТ, ХӨСҮТ, УХТЭ, СЭМҮТ, ЭСҮТ-ийн эмч, ажилчдын 24.4%-33.0% нь сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлсэн байна.

“Тусламж, үйлчилгээний алдаа, эрсдэлгүй ажиллах боломж”-ийн талаар сэтгэл ханамжийн түвшин 87.6%-тай байна. Алдаа эрсдэлгүй ажиллах боломжийн талаар ГССҮТ-ийн эмч ажилчдын 40.2%, ЗӨСҮТ-ийн 35.0%, ЭСҮТ-ийн 51.4%, УХТЭ-ийн 29.7% нь сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлсэн нь хамгийн өндөр хувь юм.

“Тусламж, үйлчилгээний алдаа зөрчил буурсан” талаар хэрэглэгчийн 42.8% нь тийм, 12.5% нь үгүй, 44.7% нь мэдэхгүй гэсэн байна.

